



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 9 сарын 26 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

### Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,000,000 /зургаан сая/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компанийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх эдлэхгүй болохыг дурдсугай.

3. Хаалттай хүрээнд нэмж гаргахыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг Хөтөлийн “Цемент шохой” ХК /А.Шоовдор/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

